
ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагч компани нь анх 1966 онд байгуулагдаж барилгын материал, шохойн үйдвэрлэлийн салбарт үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 1992 онд Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани болсон түүхтэй. Тус компани нь анх байгуулагдсанаас хойш эдүгээ 45 жил болоод байна.

Компанийн хувьцааны хэт төвлөрлөөс хамаарч хувьцааны зах зээлийн үнэ, бодит үнийн хооронд ихээхэн зөрүү үүссэн тул 2010 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээрх нэгж хувьцааны дансны үнээр хувьцааны нэрлэсэн үнийг шинэчилж тогтоон 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 30 112 302 ширхэг хувьцаатай байхаар тогтсон. Тус компанийн 2010 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дагуу нэгж хувьцааны дансны үнэ 17 765 байсан бөгөөд нэгж хувьцаа тус бүрийг 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй байхаар шинэчлэн тогтоож, нэгж хувьцааг 177 ширхэгт хуваасан болно.

Тус компанийн үйл ажиллагаа нь 1998 оноос зогсонги байдалд орсон байсныг одоогийн өмчлөгч болон удирдлагын зүгээс 2005 оноос дахин үйл ажиллагаанд нь оруулах ажлыг хэсэгчлэн эхлүүлсэн болно. Цаашид хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг хангаж өр төлбөрийг барагдуулах, хүчин чадлыг нэмэгдүүлж технологийн шинэчлэл хийхэд 3 650 000 000 төгрөг шаардлагатай ба тус хөрөнгийг компанийн 35 хувьтай тэнцэх 16 222 300 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгон татан төвлөрүүлэх замаар санхүүжүүлэхээр шийдвэрлээд байна.

Одоо ажиллаж байгаа үйлдвэрлэлийн бааз, дэд бүтцэд тулгуурлан өндөр чанартай, бага өртөгтэй, зах зээлд өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх сүүлийн үеийн технологитой үйлдвэрийг Монголын шохойн үйлдвэрлэлийн салбарт нэвтрүүлэн ашиглах нь төслийн нэг үндэслэл болж байгаа.

Энэхүү шохойн үйлдвэрийг ашигласнаар:

- Шохойн үйлдвэрийн үндсэн түүхий эд нүүрс, шохойн чулууны технологийн ашиглалт 65-75% байсан бол нүүрс нь 100%, шохойн чулууны ашиглалт 90% болно.
- Шохойн өөрийн өртөг буурч, чанар сайжирсанаар шохойн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.
- Экологийн цэвэр үйлдвэрлэл явагдаж дутуу шаталтаас үүсэх нүүрс хүчлийн хийн ялгаралт эрс буурна.
- Шохойн чанар, стандарт олон улсын түвшинд хүрнэ.
- Шохойн чанар, хямд өртгийг дагаж хөнгөн бетон блокны чанар сайжирч өртөг хямдрана.
- Карьерийн бутлах, ангилах үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт дээшилнэ.
- Чанар дагаж борлуулалт нэмэгдсэнээр, үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт 100%-д хүрнэ.

- Дотоодын зах зээлийг хангаад зогсохгүй, бүтээгдэхүүнээ экспортлох бололцоотой болно.